



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 31 өдөр

Дугаар Б/106

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж, ажилд  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 106 дугаар зүйлийн 106.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежер Д.Зоригтбаясгалан ажилдаа орох хүсэлт гаргасан тул Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Д.Бямбасүрэнг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежер Д.Зоригтбаясгалангийн хүсэлтийг үндэслэн 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн уг албан тушаалд нь томилон ажиллуулсугай.

3. Д.Зоригтбаясгалангийн үндсэн цалинг ТЗ-7-4 шатлалаар тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5, зэрэг дэвийн нэмэгдлийг 17 хувиар тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

4. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Ч.Баярцолмон

-Хяналт шинжилгээ, үнэлгээ,  
дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Ганчимэг

-Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын хүний нөөцийн  
мэргэжилтэний албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч

Т.Баяртуяа

-Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын нярав

5. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежерийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Зоригтбаясгаланд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА